

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.5-д зааснаар Санхүүгийн зохицуулах хороонд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох үндсэн зорилтыг ханган ажиллах бүрэн эрхийг олгосон билээ.

Энэ дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос 2007, 2014 онуудад Монгол Улсын хэмжээнд мөрдүүлэхээр “Компанийн засаглалын кодекс”-ыг батлан компанийн засаглалын талаарх мэдлэг, мэдээллийг түгээх, уг зарчмуудыг хэрэгжүүлэх үндсэн суурийг тавьсан хэдий ч түүний хэрэгжилт хангалттай бус байсантай холбогдуулан зохицуулалтын салбарт компанийн засаглалын орчинг боловсронгуй болгох, сайн засаглалын зарчмуудын хэрэгжилтийг идэвхжүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 78 дугаар тогтоолоор “Компанийн засаглал, комплайнсын хэлтэс”-ийг шинээр байгуулаад байна.

Уг хэлтэс нь компанийн засаглал, комплайнсыг хөгжүүлэх стратеги бодлого, хууль тогтоомж, заавар журмыг боловсронгуй болгох, холбогдох судалгаа шинжилгээг хийх, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны дүрэм, дагаж мөрдөх шалгуур үзүүлэлт, стандарт, аргачлалыг боловсруулах, сургалт зохион байгуулах, засаглалын мэдээллийг багтаасан мэдээллийн нэгдсэн сан байгуулах зэрэг зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх юм.

Эрх зүйн орчинг боловсронгуй болгох	<ul style="list-style-type: none"> <li>▪ “Компанийн засаглалын кодекс”-ыг шинэчлэх</li> <li>▪ Банкнаас бусад санхүүгийн салбарын мэргэжлийн ёс зүйг сайжруулах</li> <li>▪ Байгууллагын комплайнсын эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг сайжруулах</li> <li>▪ Зохицуулалттай этгээд болон бүртгэлтэй хувьцаат компанид засаглал болон комплайнсын чиглэлээр мөрдөх дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулах</li> </ul>
Стратеги, бодлогын баримт бичиг боловсруулах,	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын хариуцлага болон урамшууллыг компанийн засаглалын түвшинтэй уялдуулах</li> <li>▪ Комплайнсын эрсдэлийг удирдах хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх</li> <li>▪ Байгууллагын комплайнсын түвшинг тогтоон цаашид авах арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулах</li> <li>▪ Комплайнсын үйл ажиллагааны хөтөлбөрийн нэгдсэн стандарт боловсруулах</li> </ul>
Төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>▪ Компанийн засаглалын кодексыг шинэчлэн боловсруулах</li> <li>▪ Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах</li> </ul>
Олон улсын стандарт, зарчмуудыг мөрдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>▪ Компанийн засаглалын кодекс, зарчмууд</li> <li>▪ Комплайнсын стандарт</li> </ul>
Сургалт, семинар зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>▪ Компанийн эрх бүхий албан тушаалтны ахисан шатны сургалт</li> <li>▪ Байгууллагын комплайнсын хяналтын тогтолцооны үйл ажиллагаа</li> <li>▪ Гарын авлага, тараах материал, брошур бэлтгэж зохицуулалтын байгууллага, олон нийтийн хүртээл болгох</li> <li>▪ Компанийн засаглал болон комплайнсын чиглэлээр хэлэлцүүлэг, форум, чуулганыг зохион байгуулах</li> </ul>

Судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>▪ Зохицуулалттай этгээд болон бүртгэлтэй хувьцаат компанийн засаглал болон комплайнсын хяналтын чиглэлээр судалгаа хийх</li> <li>▪ Зохицуулалттай этгээд болон бүртгэлтэй хувьцаат компанийн засаглал, комплайнсын эрсдэлийн үнэлгээг хийх</li> </ul>
Үзлэг, хяналт шалгалт хийх, гарсан зөрчлийг арилгуулах	<ul style="list-style-type: none"> <li>▪ Компанийн засаглалын кодекс, зарчмуудын хэрэгжилт</li> <li>▪ ХК-уудын засаглалын бүтэц, үйл ажиллагаа</li> <li>▪ Байгууллагын комплайнсын хяналтын тогтолцоо, хариуцсан нэгж, ажилтны үйл ажиллагаа</li> </ul>

Санхүүгийн зохицуулах хорооноос 2014 онд “Компанийн засаглалын кодекс”-ыг шинэчлэн баталснаар компаниуд засаглалын талаар ойлголт, мэдлэг мэдээлэлтэй болж компанийн засаглалаа сайжруулах, засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх боломж, үндэс суурийг тавьж байсан. Гэсэн хэдий ч түүний хэрэгжилт төдийлөн хангалттай бус, оролцогч талуудын чадавх харилцан адилгүй, эрх зүйн болон компанийн өөрийн зохицуулалт сул байгаагаас үүдэн компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага сул, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын оролцоог хангуулах байдал хангалтгүйгээс үүдэн эрх ашиг нь хохирох асуудал цөөнгүй гарч байна.

Иймд ИХ20/Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 2015 онд Компанийн засаглалын тулгуур зарчмуудыг сайжруулан шинэчлэн батламжилсан бөгөөд тэдгээрт нийцүүлэн манай оронд мөрдөгдөж буй “Компанийн засаглалын кодекс”-ыг шинэчлэн сайжруулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Компанийн засаглалын зарчмуудад тулгуурлан хувьцаат компани болон санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нэмэлт шаардлага, шалгуурыг бий болгон хэрэгжүүлэхийн тулд компанийн засаглалын болон комплайнсын түвшний суурь үнэлгээг хийх, эрх зүйн болон зохицуулалтын орчинг сайжруулах, зах зээлд оролцогчдод мэдээ, мэдээлэл түгээх, шаталсан сургалт зохион байгуулах, гарын авлага, тараах материалыг бэлтгэх, заавар, зөвлөмж, аргачлалыг боловсруулах бэлтгэл ажлууд хийгдэж эхэллээ.

Мөн банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад комплайнсын сайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хууль, эрх зүйн орчин, арга зүйн талаасаа туслалцаа дэмжлэг үзүүлэх, комплайнсын менежментийн олон улсын стандартыг баримтлах талаар заавар зөвлөмж хүргүүлэх, санхүүгийн салбарын байгууллагуудын мэргэжлийн ёс зүйг сайжруулах банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын комплайнсын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах, мэдээллээр хангах, комплайнсын хэрэгжилтийг хянах зэрэг ажлууд шат дараатайгаар хэрэгжинэ.